



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/112

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 15 дугаар зүйлийн 15.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг орон нутгийн хүн амын эрүүл мэндийн чиглэлээрх хэрэгцээ шаардлагад тулгуурлан “Монпэн” төслийг хэрэгжүүлэх төслийн ажлын албаны төлөөлөгч, Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, Сүрьеэгийн үндэсний зөвлөгөөн, сургалтыг аймагт хамтран зохион байгуулах Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн яамны төлөөлөгчид, Глобаль сангийн төлөөлөгчид, НҮБ-ын ХАС-ийн зочид төлөөлөгчидтэй хамтын ажиллагааны уулзалт, хэлэлцүүлэх хийх сургалтын бэлтгэл ажлын арга хэмжээний зардалд 2,581,010 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 2,581,010 (Хоёр сая таван зуун наян нэгэн мянга арван) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН